



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 01 өдөр

Дугаар Б/25

Чингис хот

Б.Дарханбаатарыг түр орлон гүйцэтгэгчээр
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 3.3, 3.3.4, 4.3, 4.3.3, 4.4 дэх заалт, 2014 оны 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баатарцогтын Дарханбаатарыг Хууль, эрх зүйн хэлтсийн Хууль тогтоомжийн мэдээлэл, системчлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 2017 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Дарханбаатарын үндсэн цалинг ТЗ-5-2 шатлалаар тогтоож 540033 /таван зуун дөчин мянга гучин гурван/ төгрөгөөр тооцон олгохыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д зөвшөөрсүгэй.

3. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Л.Бат-Октябрь -Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд: Ч.Болормаа -Архив, бичиг хэргийн эрхлэгч

Л.Очирмаа -Аж ахуйн нярав

4. Хууль, эрх зүйн хэлтсийн Хууль тогтоомжийн мэдээлэл, системчлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Дарханбаатарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР